

## ТАНИЛЦУУЛГА

“Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хэрэгжилтийн тухай

Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор 2009 оны 7 дугаар сард “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль” болон уг хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2009 оны 55 дугаар тогтоол тус тус батлагдан гарснаар ойн сан бүхий газар, гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газар, усан хангамжийн эх үүсвэрүүд, тэдгээрийн хамгаалалтын бүсэд ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох талаархи Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан асуудал бодитой хэрэгжих эрх зүйн үндэслэл бүрдсэн юм.

Энэхүү хуулийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн заагийг тогтоох, хилийн заагт ашигт малтмалын хайгуул, ашиглалт явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг зогсоох, байгаль орчныг нөхөн сэргээх, нөхөн олговор олгох журам баталж хэрэгжүүлэх зэрэг ажлыг үе шаттайгаар хийх үүргийг холбогдох яам, агентлагт өгч, хяналт тавьж ажиллаж байна.

1. ***Хуулийн 3 дугаар зүйлд заасан ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон “гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн зааг”-ийг тогтоох ажлын талаар:***

“Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2010 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс эхлүүлэн орон даяар усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоох ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Усны газар, Байгаль орчныг хамгаалах иргэний зөвлөл /ТББ/-тэй хамтран зохион байгуулж 2010 оны 6 дугаар сарын 20-нд дуусгасан байна. Үүнд:

### **- Гол мөрний урсац бүрэлдэх эх:**

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулан гол мөрний урсацын дийлэнх хэсэг буюу 70 гаруй хувь нь бүрэлдэн бий болдог “Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн зааг”-ийг бүсчлэлийн кодоор кодлон дугаарласан 18 аймгийн 109 талбай, 6958 цэгийн газарзүйн солбицол, талбай тус бүрийн хилийн урт /км/, талбай /км.кв/, харъяалах аймаг, сумаар нь нэг бүрчлэн тогтоосон.

### **- Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс:**

Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг тогтоох ажлыг Монгол орны бүх аймаг, сум, суурин газарт хүрч ажиллан Усны тухай хуулийн 16.1.5-д заасны дагуу 21 аймгийн 314 сумын Засаг даргын захирамжийг гаргуулан 89049,49 км.кв талбайг хамгаалалтад авч Усны мэдээллийн санд хүлээн авч нэгтгэн боловсруулсан. Улсын хэмжээнд 2007 онд гадаргын усны тоо бүртгэлээр устай гэж бүртгэгдсэн гол горхи, булаг шанд, нуур тойромын 71.6 хувийг хамруулан энгийн хамгаалалтын бүсийг тогтоосон. Энгийн хамгаалалтын бүсийг газарзүйн байршил, геоморфологи, геологийн тогтоцоос нь шалтгаалан хангайн уулархаг раойнд 200-500 м хүртэл, тал хээр, говийн раойнд 500-5000 м хүртэл зурвас үүсгэн “Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс”-ийг улсын хэмжээнд 3335 талбайн 2 833 700 /2.8 сая/ газарзүйн цэгийн солбицлыг тогтоосон.

**- Ойн сан бүхий газар:**

Монгол орны ойн сангийн нийт талбайн 18.8 сая гектар буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 12.03 %-ийг эзлэх ба үүний 14.2 сая.га буюу 75.4%-ийг навчит шилмүүст мод, 4.6 сая.га буюу 24.6%-ийг заган ой эзэлнэ. Ойн сангийн талбайг заган ойг оролцуулаад 20 аймгийн 228 сум, 1 хотын 7 дүүргийн нутагт янз бүрийн хэлбэр дүрс, хэмжээтэй, орон зайн байрлалын хувьд үргэлж биш зарим хэсэгт бие биеэс тасарсан 59 107 талбай /ялгарал/-аас бүрдэж байгаа полигон хэлбэртэй зургийг цэгэн хэлбэрт шилжүүлэн ойн сангийн хилийн заагийг нийт 3 536 490 цэгийн солбицлоор тогтоосон.

Засгийн газрын 2010 оны 2 дугаар сарын 24 болон 8 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн 3 дугаар зүйл 3.1-д заасан “гол, мөрний урсац бүрэлдэх эх”-ийн хилийн заагийг 109 нэгж талбайн 6958 цэгийн солбицлоор, “ойн сан бүхий талбай”-н хилийн заагийг 31089 нэгж талбайн 1,7 сая цэгийн солбицлоор, “усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс”-ийг 4460 нэгж талбайн 57313 цэгийн солбицлоор тогтоосон ажлын хэсгийн тайланг танилцуулсан.

Засгийн газраас хуулийг үе шаттайгаар хэрэгжүүлэх чиглэл өгөгдсөний дагуу 2 удаагийн хуралд танилцуулсан мэдээллийг үндэслэн Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 30 дугаар хуралдаанаар алтны шороон ордын ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хэсэгт “Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн зааг”-ийг баталж, Засгийн газрын 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 174 дүгээр тогтоол гаргуулж, 2012 оны 06 сарын 05-ны өдрийн 194 дүгээр тогтоолоор Монгол улсын хэмжээнд гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн заагийг баталгаажуулаад байна.

Уг хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмалын

хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор олгох” журмын дагуу алтны шороон ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд олгох нөхөх олговрыг тооцох яам дундын байнгын ажлын хэсэгийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2011 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хамтарсан 70/А-105/88/67(ЭБЭХЯ/БОАЖЯ/СЯ/ХЗДХЯ) тоот тушаал байгуулан ажиллаж байна.

## **2. Экологийн хохирол тооцох үйл ажиллагаа**

Алтны шороон ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд олгох нөхөх олговор олгохтой холбогдуулан тус яамнаас 12 аймгийн нутаг дэвсгэрт орших алтны шороон ордын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 242 талбай тус бүрээр байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр, нөхөн сэргээлтийн зардлын хэмжээг тогтоох зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Хохирол тооцуулах тухай” А-204 дүгээр тушаал гарган, холбогдох мэргэжлийн байгууллагын судлаачдыг газар дээр нь ажиллуулав.

Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн сэргээлтийн зардал тооцох нийт 138 аж ахуйн нэгжийн 242 тусгай зөвшөөрлийн талбайгаас 6 аж ахуйн нэгжийн 7 талбай Засгийн газрын 174 дүгээр тогтоолд сарын дараа нэмэгдэж орсон учир одоогоор тооцоо хийгдээгүй. Уг 7 тусгай зөвшөөрлийн талбайд 2012 оны 5-р сарын 01-ны дотор экологийн хохирол тооцох ажлыг хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Мөн 174 дүгээр тогтоолд алтны үндсэн ордын 6 талбай хамрагдсан учир уг талбай дээр экологийн хохирол тооцох ажил хийгдээгүй. Эдгээр талбайд гүйцээн хийх ажлыг 6- сард багтаан зохион байгуулна.

Тус экологийн хохирол, нөхөн сэргээлтийн зардлыг тооцох ажилд шаардлагатай зардлыг шийдвэрлүүлэхээр Засгийн газрын 2011 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн хөрөнгө шийдвэрлүүлэх тухай 201 дүгээр тогтоол гаргуулан 1,1 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

Байгаль орчны хохирол, нөхөн сэргээлтийн зардал тооцох ажлын хүрээнд байгаль орчны үнэлгээний мэргэжлийн компаниудын хээрийн судалгааны явцад хийсэн хэмжилтэд 226 тусгай зөвшөөрлийн нийт 59.27 мян.га талбай хамрагдсаны 76.7 хувь буюу 45.47 мян.га талбай нь “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газруудын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” Монгол Улсын хуулийн заалтаар хориглосон бүсэд багтаж байна. Тусгай зөвшөөрлийн нийт талбайн 21.2 хувь буюу 12.56 мян.га талбай ашиглагдаагүй байгаа бол хуулиар хориглосон бүсийн талбайн 19.9 хувь буюу 9.05 мян.га талбай нь ашиглагдаагүй байна.

Тусгай зөвшөөрөл нь цуцлагдах нийт талбайд 5.08 мян.га, хуулиар хориглосон бүсэд 4.79 мян.га талбай алт олборлосны улмаас эвдрэлд орсон байна. Мөн 711.8 га талбай тусгай зөвшөөрлийн хилийн гадна талд эвдэрчээ. Өөрөөр хэлбэл, нийт эвдэрсэн талбайн 66.2 хувь нь хуулиар хориглосон бүсэд, 10.3 хувь нь тусгай

зөвшөөрлөөр олгосон талбайгаас гадна байна. Хуулиар хориглосон бүсэд эвдэрсэн талбайн 34.7 хувь нь Сэлэнгэ аймагт, 16.28 хувь нь Заамарын бүс нутагт, 30.28 хувь нь Архангай, Өвөрхангай аймгийн нутагт, 9.41 хувь нь Баянхонгор аймагт, 7.63 хувь нь Дархан-Уул аймагт, 1.71 хувь нь Хэнтий, Дорнод аймагт, 0.37 хувь нь Увс, Хөвсгөл аймгуудын нутагт байна.

Дээрх хэмжээний эвдрэлтэй талбайд тооцсон байгаль орчны хохирлын нийт хэмжээ 1.16 их наяд төгрөг, үүний 57.9 хувь буюу 672.0 тэрбум төгрөг нь хуулиар хориглосон бүсэд учруулсан хохирол байна. Хуулиар хориглосон бүсэд тогтоосон хохирлын 31.56 хувь нь Архангай, Өвөрхангай аймагт, 20.9 хувь нь Сэлэнгэ аймагт, 8.57 хувь нь Баянхонгор аймагт, 33.32 хувь нь Заамарын бүс нутагт ногдож байна.

Эвдрэлд орсон нийт талбайн 25.7 хувь буюу 2.1 мян.га–д техникийн нөхөн сэргээлт хийж хэлбэршүүлсэн бол 7.8 хувь буюу 632.2 га–д биологийн нөхөн сэргээлт хийж ургамалжуулсан байна. Цаашид 5057.1 га талбайд техникийн, 7096.1 га-д биологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай гэсэн тооцоо гараад байна. Хуулиар хориглосон бүсэд нөхөн сэргээх шаардлагатай нийт талбайд бүрэн нөхөн сэргээлт хийхэд нийт 54.7 тэрбум төгрөг шаардагдах тооцоо гарсан. Түүний 32.3 хувь нь техникийн нөхөн сэргээлтэд, 41.7 хувь нь ойн санг нөхөн сэргээхэд, 11.8 хувь нь биологийн нөхөн сэргээлтэд, үлдэх 14.1 хувь нь голын голдирлыг нөхөн сэргээхэд тус тус зарцуулагдахаар тооцоологдсон байна.

Мөн хуулиар хориглосон бүсийн нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах 54.7 тэрбум төгрөгийн 24.1 хувь буюу 13.2 тэрбум төгрөг Архангай, Өвөрхангай аймагт, 37.9 хувь буюу 20.7 тэрбум төгрөг Сэлэнгэ аймагт, 20.2 хувь буюу 11.0 тэрбум төгрөг Заамарын бүс нутагт, 5.6 хувь буюу 3.1 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 9.9 хувь буюу 5.4 тэрбум төгрөг Баянхонгор аймагт, 2.2 хувь буюу 1.2 тэрбум төгрөг Хэнтий, Дорнод, Хөвсгөл, Увс аймгуудын нутагт эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд шаардагдахаар байна.

Алтны шороон ордын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 226 талбай тус бүрээр байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр, нөхөн сэргээлтийн зардлын хэмжээг тооцсон ажлын дүнг 2012 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ЭБЭХЯ-нд хүргүүлээд байна.

### **3. Дүгнэлт**

Энэ хуулийг хэрэгжүүлэх талаар тус яам өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах ажлуудыг бүрэн хийсэн гэж үзэж байна. Тухайлбал:

“Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрын хилийн зааг”-ийг тогтоох ажил нь цаг хугацаа, хөрөнгө мөнгө, техникийн болон нарийн мэргэжил шаардсан ажил байсан бөгөөд уг ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, Усны газар, Ашигт малтмалын газрын холбогдох

мэргэжилтэн, албан хаагчид хамгийн богино хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит бүхий л аргыг ашиглан гүйцэтгэсэн.

“Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрын хилийн зааг”-ийг тогтоосон цэг, солбицол бусад мэдээллийг Монгол улсын ойн болон усны мэдээллийн нэгдсэн санд оруулсан материал нь хэвлэлийн /А4/ хэмжээний цаасаар нийт 11 000 орчим хуудас, 39 боть материал болсон байна.

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн заагийг тогтоох, хилийн заагт алтны шороон ордын хайгуул, ашиглалт явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг зогсоох, байгаль орчныг нөхөн сэргээх, нөхөн олговор олгохтой холбогдсон асуудлуудыг Засгийн газрын хуралд оруулж, үе шаттайгаар шийдвэрлүүлэхээр холбогдох яам, агентлагтай хамтран ажиллаж байна.

#### **4. Хуулийг хэрэгжүүлэхэд цаашид авах арга хэмжээний санал:**

Хуулийг дараах үе шаттайгаар хэрэгжүүлэх. Үүнд:

1. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газартай давхацсан алтны шороон ордын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хэсэгт уурхайн хаалт, нөхөн сэргээлт, байгаль орчны мониторингийн үйл ажиллагааг аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр гүйцэтгэх ажлыг эрчимжүүлэх;
2. Хуулийг үе шаттай хэрэгжүүлэх дараагийн шатны ажлын хүрээнд тусгай зөвшөөрлийг цуцлах асуудлыг тодорхой болгож, хуулийн хүрээнд аж ахуйн нэгж байгууллагад тавих хяналтыг сайжруулах;
3. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт оршиж буй алтны шороон ордын зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн талбайд нөхөн сэргээлт хийлгүй орхисон тул тусгай зөвшөөрөл эзэмшигч, эзэн холбогдогчийг ойрын үед тодруулж, тухайн талбайд нөхөн сэргээлтийг бүрэн хийлгэх;

-000-

**Байгаль орчин, ногоон хөгжлийн яам**

## ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд

Монгол Улсын Их Хурлаас “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийг 2009 оны 7 сарын 16-ны өдөр батлан гаргасан.

Хуулийг хэрэгжүүлэхээр дараах 2 үндсэн чиглэлээр Ажлын хэсгүүд байгуулагдан ажилласан.

### Хил хязгаарыг тогтоох чиглэлээр

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас (хуучнаар) хуулиар хориглосон талбайн хилийн заагийн цэгийн солбицлыг боловсруулан Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолоор алтны шороон ордод хамаарах хэсгийг, 2012 он 194 дүгээр тогтоолоор бүхэлд нь тус тус батлуулсан.

Алтны шороон ордуудын хил хязгаарт нийт 137 аж ахуйн нэгжийн 242 тусгай зөвшөөрөл хамрагдсаны 65 нь хэсэгчлэн давхцалтай байв. Хил заагийг хүлээн зөвшөөрөхгүй маргаан үүсгэсэн 13 ашиглалтын тусгай зөвшөөрлөөс алтны үндсэн ордтой болох нь ЭБМЗ-өөр тогтоогдсон доорх нэр бүхий 5 тусгай зөвшөөрлийн талбай байна.

№	Т/З дугаар	Компаний нэр	Тайлбар ирүүлсэн байдал
1	8998	ГБНБ	Давхцалгүй
2	15586	Жотойнбажууна	Давхцалгүй
3	9623	Монжап-Интернэшнл	Давхцалгүй
4	11860	Дацантрейд	Давхцалгүй
5	13421	Дацантрейд	Давхцалгүй
6	267	Хосхас	Хил зөвшөөрөхгүй
7	10632	Хартарвагатай	Хил зөвшөөрөхгүй
8	11881	Хосхас	Хил зөвшөөрөхгүй
9	7700	Нарийн гол гоулд	Шороон орд биш
10	8085	Уртхошуу	Шороон орд биш
11	8728	Пенинсула майнинг	Шороон орд биш
12	11025	Гацуурт	Шороон орд биш
13	113082	Брэйвхарт ресорсиз	Шороон орд биш

Хуулиар хориглосон талбайд нийт 31,7 тонн алтны нөөцтэй гэсэн тооцоо гарсан. Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолоор хориглосон талбайд хамаарах алтны шороон ордуудын уурхайн үйл ажиллагааг зогсоосноос гар аргаар ашигт малтмал олборлогч иргэд хууль бусаар үйл ажиллагаа явуулах, аж ахуйн нэгжүүд өөрсдөө мөн энэ хэлбэрт шилжиж ажиллах сөрөг хандлага гарсаар байна. Цаашид харуул хамгаалалтгүй орхигдох нөөцийн үлдэгдэлтэй бүх л талбайнуудад иргэд хууль бусаар гар аргаар олборлолт явуулах магадлал өндөр байна.

Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор батласан хил зааг нь Ашигт малтмалын газрын кадастрын дүрс зургийн программд буулгах боломжгүй, солбицлын маш их алдаатай байсан учир хамаарах тусгай зөвшөөрлүүдийг өнөөдрийг хүртэл тодорхойлж чадаагүй байна. Уг тогтоол нь 2012 оны 6 дугаар сард батлагдаж, Шинэчлэлийн Засгийн газар байгуулагдсанаас хойш буюу тухайн оны 10 дугаар сард Уул уурхайн яаманд ирсэн байдаг. Тогтоолын хавсралтыг богино хугацаанд, асар их алдаатай, туйлын хариуцлагагүй боловсруулсан, батлагдсан даруйдаа салбарын яаманд хүргэгдээгүй, түүнчлэн УИХ-ын сонгуулийн

компанит ажлын үед батлагдсан зэрэг нь улс төрийн зорилго агуулсан байхыг үгүйсгэхээргүй байна.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 2010 онд тогтоож байсан хил хязгаарт тухайн үеийн судалгаагаар хайгуулын 1391, ашиглалтын 391 тусгай зөвшөөрөл хамрахаар байсан. Үүн дээр орон нутгаас тогтоосон энгийн хамгаалалтын бүсийг нэмж тооцох үед дээр дурьдсан алдаа, дутагдлуудыг гарсан гэж тайлбарладаг.

Хилийн заагийн цэгийн солбицлын алдааг засаж дүрс зургийн мэдээллийн санд нэгтгэхээр Уул уурхайн яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамтай хамтран ажиллаж байна.

#### Нөхөх олговор тооцох чиглэлээр

Хуулийн 4.6-д заасны дагуу аж ахуйн нэгжүүдэд олгох нөхөх олговор олгох журмыг холбогдох яамын хамтарсан ажлын хэсэг боловсруулж Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолоор батлуулсан. Журмын дагуу нөхөх олговор авахаар хүсэлтээ 96 аж ахуйн нэгж гаргасан ба нийт 222 тэрбум төгрөг нэхэмжилсэн. Нөхөх олговор болон түүнд хөндлөнгийн аудит хийхэд шаардагдах зардлын эх үүсвэр одоогоор тулгамдсан асуудал болоод байна.

Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолд хамрагдсан 242 ашиглалтын тусгай зөвшөөрлийн 66 нь нөхөх олговор авах хүсэлт ирүүлээгүй учир цуцлагдсан байна. Үлдсэн 163-ын 65 нь хэсэгчлэн давхцалтай бөгөөд үүний 40 нь нөхөх олговроо "0" төгрөгөөр тооцуулж давхцалгүй хэсэгтээ үйл ажилагаагаа үргэлжлүүлэн явуулах, 25 нь нөхөх олговор аваад үйл ажиллагаа явуулах санал ирүүлсэн. Бүхэлдээ давхцалтай 98 тусгай зөвшөөрлийг эзэмшигчид нөхөх олговор авах хүсэлт гаргасан.

Тогтоолд хамрагдсан тусгай зөвшөөрлүүдийн эзэмшигчдийн 22 нь гадаадын 100% хөрөнгө оруулалттай, 14 нь хамтарсан, 101 нь дотоодын 100% хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд байв. Сүүлийн 5 жилийн судалгаагаар эдгээр аж ахуйн нэгжүүдээс хуульд хамрагдсан талбайдаа 62,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хувьд тухайн орныхоо төрийн байгууллагаас зээл авсан, дотоодын компаниуд тусгай зөвшөөрлөө банкны барьцаанд тавьсан байснаас хүндрэлтэй асуудлууд үүссэн.

Дээр дурьдсан хүндрэлүүд хуулийн хэрэгжилтийг удаашруулж байгаа бөгөөд хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр хийгдсэн ажлуудын дүнг нэгтгэн дүгнэхэд хил заагийн маргаан, нөхөх олговрыг хэрхэн шийдвэрлэх, зарим хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд талбайдаа хайгуул хийгээд ашигт малтмалын орд илрүүлж чадаагүй зардлаа энэ хуулийг ашиглан улсаас нөхөх олговор хэлбэрээр авч эрсдэлээ хаах магадлал өндөр байгаа зэрэг ээдрээтэй, шийдвэрлэгдээгүй асуудал олон байна.

Шинэчлэлийн Засгийн газар байгуулагдсанаас хойш Уул уурхайн сайдын тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хийгдсэн ажлуудын мэдээллийг нэгтгэн, тулгамдаж буй асуудлуудын хамт Засгийн газрын хуралдаанд 2013 оны 02 дугаар сарын 23-ны өдөр танилцуулсан. Энэ хуралдаанаас шийдвэрлэсний дагуу МУ-ын Ерөнхий сайдын 34 дүгээр захирамжаар мөн хуулийн хэрэгжилтийн талаар судалж дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхайн сайдаар ахлуулан байгуулсан. Ажлын хэсгийн удирдамж, төлөвлөгөө боловсруулан, Дэд ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Мөн энэ оны 2 дугаар сард УУЯ, БОНХЯ-ны хамтарсан Ажлын хэсэг байгуулагдан Засгийн газрын 174, 194 дүгээр тогтоолуудын хавсралтаар батласан хил заагийн солбицлын алдааг засварлахаар ажиллаж байна.

УИХ-аар шийдвэрлүүлэх асуудлууд

Хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй нөхцөл байдалд үндэслэн дараах арга хэмжээг авах саналыг танилцуулж байна. Үүнд:

- Нөхөх олговор болон түүнд хөндлөнгийн аудит хийхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;
- Байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг тооцон аж ахуйн нэгжийн нэхэмжилсэн нөхөх олговроос хасаж тооцох хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Нэхэмжилсэн нөхөх олговорт дүйцүүлэн хуулиар хориглоогүй нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлох боломж олгох замаар аж ахуйн нэгтэй тохиролцох;
- Орон нутгийн удирдлагаас өөрийн үзэмжээр тогтоож буй усны хамгаалалтын бүсийн дээд хэмжээг холбогдох хуулиар тогтоох;

Хууль хэрэгжүүлэхэд үүсээд байгаа нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудыг харгалзан үзэж зохих шийдвэрийг гаргуулах саналыг үүгээр танилцуулж байна.

ТАНИЛЦСАН:

УУЛ УУРХАЙН САЙД

Д.ГАНХУЯГ

ХЯНАСАН:

УУЯ-НЫ БХЗГ-ЫН ДАРГА

Б.БАТХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:

УУЯ-НЫ БХЗГ-ЫН АХЛАХ

МЭРГЭЖИЛТЭН

С.ГАН-ОЧИР

2013 оны 05 дугаар сарын 27-ны өдөр



**Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийн талаар хийсэн ажлын тухай товч танилцуулга**

“Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хэрэгжилтэд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, аялал жуулчлал, геологи, уул уурхайн хяналтын газрын Геологи, уул уурхайн хяналтын хэлтсийн 8 улсын байцаагч, аймаг, нийслэлийн МХГ-ын 96 байгаль орчин, геологи уул уурхайн хяналтын улсын байцаагч, сумдын 341 байгаль орчны хяналтын улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэйгээр хяналт тавин ажиллаж байна.

“Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хууль 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр батлагдан гарсан. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хил заагийг тогтоох, хуульд хамрагдсан тусгай зөвшөөрлийг цуцлахдаа уг тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор төлөх журмыг тус тус Засгийн газар батлах гаргахаар хуульд зааж өгсөн. Үүний дагуу Засгийн газраас 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор олгох журам”-ыг батлах тухай 299 дүгээр тогтоол, 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдөр алтны шороон ордын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хэсэгт “Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн зааг”-ийг хэсэгчлэн тогтоох тухай 174 дүгээр тогтоолыг тус тус батлан гаргасан.

Засгийн газрын 299 дүгээр тогтоолоор:

1. Нөхөх олговрыг олгоход шаардагдах хөрөнгийг тухайн жилийн төсвийн төсөлд тусган батлуулж байхыг Сангийн сайд С.Баярцогт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх нарт,
2. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт алтны шороон ордын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хэсэгт уурхайн хаалт, нөхөн сэргээлт, байгаль орчны мониторингоос бусад үйл ажиллагааг зогсоохыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт,
3. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор олгох журмын хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллан явц, үр дүнгийн талаар тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Сангийн сайд С.Баярцогт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх нарт тус тус даалгасан билээ.

Засгийн газрын 174 дүгээр тогтоолоор:

1. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Р.Содхүү)-т,
2. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт алтны шороон ордын ашиглалтын үйл ажиллагаа явуулснаар байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээ, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн

зардлын хэмжээг тогтоох ажилд шаардагдах зардлыг тооцож Засгийн газрын нөөц сангаас гаргаж, Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд нэмэлт оруулах замаар хөрөнгийг нөхөн бүрдүүлэхийг Сангийн сайд С.Баярцогтод тус тус даалгасан байна.

Хуулийн 3 дугаар зүйлд заасан ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон “гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн зааг”-ийг тогтоох ажлыг зохион байгуулахаар БОАЖЯ дараах арга хэмжээг авч ажилласан байна.

“Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2010 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс эхлүүлэн орон даяар усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоох ажлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Усны газар, Байгаль орчныг хамгаалах иргэний зөвлөл /ТББ/-тэй хамтран зохион байгуулж 2010 оны 6 дугаар сарын 20-нд дуусгасан байна. Үүнд:

#### Гол мөрний урсац бүрэлдэх эх:

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулан гол мөрний урсацын дийлэнх хэсэг буюу 70 гаруй хувь нь бүрэлдэн бий болдог “Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн зааг”-ийг бүсчлэлийн кодоор кодлон дугаарласан 18 аймгийн 109 талбай, 6958 цэгийн газарзүйн солбицол, талбай тус бүрийн хилийн урт /км/, талбай /км.кв/, харьяалах аймаг, сумаар нь нэг бүрчлэн тогтоосон.

#### Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс:

Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг тогтоох ажлыг Монгол орны бүх аймаг, сум, суурин газарт хүрч ажиллан Усны тухай хуулийн 16.1.5-д заасны дагуу 21 аймгийн 314 сумын Засаг даргын захирамжийг гаргуулан 89049,49 км.кв талбайг хамгаалалтад авч Усны мэдээллийн санд хүлээн авч нэгтгэн боловсруулсан. Улсын хэмжээнд 2007 онд гадаргын усны тоо бүртгэлээр устай гэж бүртгэгдсэн гол горхи, булаг шанд, нуур тойромын 71.6 хувийг хамруулан энгийн хамгаалалтын бүсийг тогтоосон. Энгийн хамгаалалтын бүсийг газарзүйн байршил, геоморфологи, геологийн тогтоцоос нь шалтгаалан хангайн уулархаг раойнд 200-500 м хүртэл, тал хээр, говийн раойнд 500-5000 м хүртэл зурвас үүсгэн “Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс”-ийг улсын хэмжээнд 3335 талбайн 2 833 700 /2.8 сая/ газарзүйн цэгийн солбицлыг тогтоосон.

#### Ойн сан бүхий газар:

Монгол орны ойн сангийн нийт талбайн 18.8 сая гектар буюу улсын нийт нутаг дэвсгэрийн 12.03 %-ийг эзлэх ба үүний 14.2 сая.га буюу 75.4%-ийг навчит шилмүүст мод, 4.6 сая.га буюу 24.6%-ийг заган ой эзэлнэ. Ойн сангийн талбай нь заган ойг оролцуулаад 18 аймгийн 215 сум, 1 хотын 6 дүүргийн нутагт янз бүрийн хэлбэр дүрс, хэмжээтэй, орон зайн байрлалын хувьд үргэлж биш зарим хэсэгт бие биеэс тасарсан 300 000 орчим талбай /ялгарал/-аас бүрдэж байна. Ойн сан бүхий газарт хамрагдаж байгаа дээрх 300 000 орчим полигон хэлбэртэй зургийг цэгэн хэлбэрт шилжүүлэн ойн сангийн хилийн заагийг нийт 1725237 цэгийн солбицлоор тус тус тогтоогоод байна.

Засгийн газрын 2010 оны 2 дугаар сарын 24 болон 8 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн 3 дугаар зүйл 3.1-д заасан “гол, мөрний урсац бүрэлдэх эх”-ийн хилийн заагийг 109 нэгж талбайн 6958 цэгийн солбицлоор, “ойн сан бүхий талбай”-н хилийн заагийг 31089 нэгж талбайн 1,7 сая цэгийн солбицлоор, “усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын

бүс"-ийг 4460 нэгж талбайн 57313 цэгийн солбицлоор тогтоосон ажлын хэсгийн тайланг танилцуулсан.

Засгийн газраас хуулийг үе шаттайгаар хэрэгжүүлэх чиглэл өгөгдсөний дагуу 2 удаагийн хуралд танилцуулсан мэдээллийг үндэслэн Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 30 дугаар хуралдаанаар алтны шороон ордын ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хэсэгт "Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн зааг"-ийг баталж, Засгийн газрын 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 174 дүгээр тогтоол гаргуулаад байна.

Уг хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор олгох" журмын дагуу алтны шороон ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд олгох нөхөх олговрыг тооцох яам дундын байнгын ажлын хэсэгийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2011 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хамтарсан 70/А-105/88/67(ЭБЭХЯ/БОАЖЯ/СЯ/ХЗДХЯ) тоот тушаал байгуулан ажиллаж байна.

#### Экологийн хохирол тооцох үйл ажиллагаа

Алтны шороон ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд олгох нөхөх олговор олгохтой холбогдуулан тус яамнаас 12 аймгийн нутаг дэвсгэрт орших алтны шороон ордын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 242 талбай тус бүрээр байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр, нөхөн сэргээлтийн зардлын хэмжээг тогтоох зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын "Хохирол тооцуулах тухай" А-204 дүгээр тушаал гарган, холбогдох мэргэжлийн байгууллагын судлаачдыг газар дээр нь ажилласан.

Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн сэргээлтийн зардал тооцох нийт 138 аж ахуйн нэгжийн 242 тусгай зөвшөөрлийн талбайгаас 6 аж ахуйн нэгжийн 7 талбай Засгийн газрын 174 дүгээр тогтоолд сарын дараа нэмэгдэж орсон учир одоогоор тооцоо хийгдээгүй. Уг 7 тусгай зөвшөөрлийн талбайд 2012 оны 5-р сарын 01-ны дотор экологийн хохирол тооцох ажлыг хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Мөн 174 дүгээр тогтоолд алтны үндсэн ордын 6 талбай хамрагдсан учир уг талбай дээр экологийн хохирол тооцох ажил хийгдээгүй.

Тус экологийн хохирол, нөхөн сэргээлтийн зардлыг тооцох ажилд шаардлагатай зардлыг шийдвэрлүүлэхээр Засгийн газрын 2011 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн хөрөнгө шийдвэрлүүлэх тухай 201 дүгээр тогтоол гаргуулан 1,1 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

Байгаль орчны хохирол, нөхөн сэргээлтийн зардал тооцох ажлын хүрээнд байгаль орчны үнэлгээний мэргэжлийн компаниудын хээрийн судалгааны явцад хийсэн хэмжилтэд 226 тусгай зөвшөөрлийн нийт 59.27 мян.га талбай хамрагдсаны 76.7 хувь буюу 45.47 мян.га талбай нь "Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газруудын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай" Монгол Улсын хуулийн заалтаар хориглосон бүсэд багтаж байна. Тусгай зөвшөөрлийн нийт талбайн 21.2 хувь буюу 12.56 мян.га талбай ашиглагдаагүй байгаа

бол хуулиар хориглосон бүсийн талбайн 19.9 хувь буюу 9.05 мян.га талбай нь ашиглагдаагүй байна.

Тусгай зөвшөөрөл нь цуцлагдах нийт талбайд 5.08 мян.га, хуулиар хориглосон бүсэд 4.79 мян.га талбай алт олборлосны улмаас эвдрэлд орсон байна. Мөн 711.8 га талбай тусгай зөвшөөрлийн хилийн гадна талд эвдэрчээ. Өөрөөр хэлбэл, нийт эвдэрсэн талбайн 66.2 хувь нь хуулиар хориглосон бүсэд, 10.3 хувь нь тусгай зөвшөөрлөөр олгосон талбайгаас гадна байна. Хуулиар хориглосон бүсэд эвдэрсэн талбайн 34.7 хувь нь Сэлэнгэ аймагт, 16.28 хувь нь Заамарын бүс нутагт, 30.28 хувь нь Архангай, Өвөрхангай аймгийн нутагт, 9.41 хувь нь Баянхонгор аймагт, 7.63 хувь нь Дархан-Уул аймагт, 1.71 хувь нь Хэнтий, Дорнод аймагт, 0.37 хувь нь Увс, Хөвсгөл аймгуудын нутагт байна.

Дээрх хэмжээний эвдрэлтэй талбайд тооцсон байгаль орчны хохирлын нийт хэмжээ 1.16 их наяд төгрөг, үүний 57.9 хувь буюу 672.0 тэрбум төгрөг нь хуулиар хориглосон бүсэд учруулсан хохирол байна. Хуулиар хориглосон бүсэд тогтоосон хохирлын 31.56 хувь нь Архангай, Өвөрхангай аймагт, 20.9 хувь нь Сэлэнгэ аймагт, 8.57 хувь нь Баянхонгор аймагт, 33.32 хувь нь Заамарын бүс нутагт ногдож байна.

Эвдрэлд орсон нийт талбайн 25.7 хувь буюу 2.1 мян.га–д техникийн нөхөн сэргээлт хийж хэлбэршүүлсэн бол 7.8 хувь буюу 632.2 га–д биологийн нөхөн сэргээлт хийж ургамалжуулсан байна. Цаашид 5057.1 га талбайд техникийн, 7096.1 га–д биологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай гэсэн тооцоо гараад байна. Хуулиар хориглосон бүсэд нөхөн сэргээх шаардлагатай нийт талбайд бүрэн нөхөн сэргээлт хийхэд нийт 54.7 тэрбум төгрөг шаардагдах тооцоо гарсан. Түүний 32.3 хувь нь техникийн нөхөн сэргээлтэд, 41.7 хувь нь ойн санг нөхөн сэргээхэд, 11.8 хувь нь биологийн нөхөн сэргээлтэд, үлдэх 14.1 хувь нь голын голдирлыг нөхөн сэргээхэд тус тус зарцуулагдахаар тооцоологдсон байна.

Мөн хуулиар хориглосон бүсийн нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах 54.7 тэрбум төгрөгийн 24.1 хувь буюу 13.2 тэрбум төгрөг Архангай, Өвөрхангай аймагт, 37.9 хувь буюу 20.7 тэрбум төгрөг Сэлэнгэ аймагт, 20.2 хувь буюу 11.0 тэрбум төгрөг Заамарын бүс нутагт, 5.6 хувь буюу 3.1 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 9.9 хувь буюу 5.4 тэрбум төгрөг Баянхонгор аймагт, 2.2 хувь буюу 1.2 тэрбум төгрөг Хэнтий, Дорнод, Хөвсгөл, Увс аймгуудын нутагт эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд шаардагдахаар байна.

Алтны шороон ордын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 226 талбай тус бүрээр байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр, нөхөн сэргээлтийн зардлын хэмжээг тооцсон ажлын дүнг 2012 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ЭБЭХЯ-нд хүргүүлээд байна.

Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолоор баталсан Нөхөх олговор олгох журмын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор авах хүсэлт гаргасан.

1. Нийт 242 тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 160 нь нөхөн олговор авах хүсэлт ирүүлсэн, 69 нь нөхөн олговор авах хүсэлт гаргаагүй бөгөөд 13 нь тайлбар бичиг (алтны үндсэн орд 7, барилга материалын орд 1, солбицол алдаатай 2, огт давхцалгүй 1, хэсэгчлэн буцаан өгч, давхцалгүй болсон 2) ирүүлжээ.
2. Нөхөх олговор авах хүсэлтээ ирүүлсэн 160 тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс:
  - тусгай зөвшөөрөл нь бүхэлдээ давхцалтай 98
  - тусгай зөвшөөрөл нь хэсэгчлэн давхцалтай нь 62. Хэсэгчлэн давхцсан тусгай зөвшөөрөл эзэмшигчид давхцалгүй хэсэгтээ үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулах эрх нь Ашигт малтмалын тухай хуулиар нээлтэй.

- 36 нь нөхөх олговрын хэмжээг “0” төгрөгөөр тооцуулж, давхцаагүй хэсэгт үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулах  
Тайлбар: 36-аас 3 нь Нөхөх олговор олгох журамд заасан хугацаанаас хоцорч хүсэлт гаргасан.
  - 26 нь хэсэгчлэн давхацсан хэсэгт нөхөх олговор авч, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах
  - тусгай зөвшөөрлийн талбай нь бүхэлдээ давхацсан 98 тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор авах хүсэлтээ тус тус ирүүллээ.
3. Нөхөх олговор авах хүсэлт ирүүлээгүй 69 тусгай зөвшөөрөл эзэмшигчид байгаагаас 1 тусгай зөвшөөрөл эзэмшигч нөхөх олговор авах хүсэлгүй гэсэн албан бичиг ирүүлсэн.

Нөхөх олговор тооцох талаар ЭБЭХЯ-аас дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Нөхөх олговрын хэмжээг “0” төгрөгөөр тооцуулж, давхцаагүй хэсэгт үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулах хүсэлтэй 36 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүсэлтийг 2012 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 1-540 тоот албан бичгээр Сангийн яам хүргүүлсэн.  
Сангийн яамны 2012 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 3-2/1457 тоотой ирүүлсэн 33 тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд олгох нөхөн олговрыг “0” төгрөгөөр тооцсон тухай шийдвэрийг үндэслэн Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолоор тогтоосон хилийн заагтай тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн давхацсан хэсгийг цуцлан, хилийн заагийн солбицолд өөрчлөлт хийх тухай хугацаатай мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд Ашигт малтмалын газрын 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн.
2. Хилийн заагт хамрагдсан 69 тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор авах тухай хүсэлт ирүүлээгүй тул нөхөх олговрын хэмжээг “0” төгрөгөөр тооцож, нөхөх олговор олгосонд тооцож шийдвэр гаргуулахаар хүсэлтийг 2012 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 1-795 тоот албан бичгээр Сангийн яамд хүргүүлсэн.  
Сангийн яамны 2012 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 3-2/1458 тоотой ирүүлсэн нөхөх олговор авах хүсэлт гаргаагүй 69 тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор олгох үндэслэлгүй байна гэсэн шийдвэрийг үндэслэн Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолоор тогтоосон хилийн заагтай тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн давхацсан хэсгийг цуцлах тухай мэдэгдэлийг Ашигт малтмалын газрын 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн албан бичгээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд өгсөн.
3. Хэсэгчлэн давхацсан 26 тусгай зөвшөөрөл эзэмшигч нөхөх олговор авч, үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулах, мөн тусгай зөвшөөрлийн талбай нь бүхэлдээ давхацсан 98 тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор авах хүсэлтээ тус тус ирүүлснийг Нөхөх олговор олгох журмын дагуу тооцож 2012 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 1-1764 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт Засгийн газрын 299, 174 дүгээр тогтоолоор үүрэг болгосны дагуу дараахь хяналт шалгалтыг 2010-2011 онд зохион байгуулж ажиллаа.

МХЕГ-ын 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу газрын даргын баталсан 01/66 тоот удирдамжаар Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Төв, Дундговь, Өмнөговь, Булган, Орхон, Хөвсгөл, Завхан, Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай, Сэлэнгэ, Дархан-Уул, Хэнтий аймаг болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрлах ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын

хэрэгжилтийг Байгаль орчин аялал жуулчлалын яам, Эрдэс баялаг эрчим хүчний яам, Ашигт малтмалын газар, МХЕГ-ын дэргэдэх Олон нийтийн зөвлөл, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, дээр дурдсан аймгуудын МХГ-уудтай хамтран 2010 оны 06 дугаар сарын 15-наас 11 дүгээр сарын 03-нд шалгасан.

Тус шалгалтын үед "Алтан Дорнод Монгол" ХХК үйл ажиллагаа эрхлээгүй, шүүхийн маргаантай, хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй гэсэн шалтгаанаар далан нууруудыг сэргээх, голыг үндсэн голидролоор урсгах ямар нэгэн арга хэмжээ аваагүй байсан. Өлзийт гол, Улаан чулуут, Шийртийн голын хөндийд "Монгол газар" ХХК 2426А, 2427А, 7207А тоот тусгай зөвшөөрлийг эзэмшиж, 2005-2009 онуудад алт олборлолтын үйл ажиллагаа явуулж, үндсэндээ бүх нөөцөө ашиглаж дууссан, 2010 оны байдлаар овоолго, эфельд хаягдсан нөөцийг дахин ашиглах замаар нөхөн сэргээлтийн ажил хийлгэхээр 11 аж ахуйн нэгжтэй ажил гүйцэтгэх түрээсийн гэрээ байгуулан ажиллаж байсныг улсын байцаагчийн актаар зогсоож, уурхайн хаалтын төлөвлөгөө, голын голидролыг сэргээх төсөл боловсруулж, хаягдлын даланг сайжруулах талаар улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. Шалгалтаар улсын хэмжээнд 708 зөрчил илрүүлж холбогдох арга хэмжээ авч ажилласнаас 69 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зөрчлийг арилгах хүртэл түр хугацаагаар зогсоох акт тогтоож, зөрчил арилгуулах 708 заалт бүхий 91 хугацаатай албан шаардлага өгч, аж ахуйн нэгжид 128.470 сая төгрөгийн шийтгэвэр, нөхөн төлбөр ногдуулж ажиллав.

Шалгалтын дүнг Засгийн газарт танилцуулж дараахь цаашид авах арга хэмжээний саналыг хүргүүлж ажилласан. Үүнд:

1. "Гол мөрний урсац бүрэдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай" хуулийн хэрэгжилттэй холбогдуулан ашиглалт явуулж байсан орд газрын нөхөн сэргээлтийн ажлын зураг төслийг хэрхэн боловсруулж, хянах, учруулсан экологийн хохирлыг тооцох, ашиглалтын үйл ажиллагаа зогсохоор үлдэж байгаа нөөцийг хууль бус олборлолтоос хэрхэн хамгаалах асуудлыг шийдвэрлэх.
2. Нийт олгогдсон 1142 ашиглалтын тусгай зөвшөөрлөөс өнөөдрийн байдлаар эдийн засгийн эргэлтэд ороогүй 581 тусгай зөвшөөрлийн асуудлыг нэг мөр шийдвэрлэх хүртэлх хугацаагаар шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон хуулийн хугацааг сунгах.
3. Зах зээлийн нөхцөлд аливаа ажил үйлчилгээнд зуучлагчийн үйл ажиллагаа шаардагдаж байгаа тул "Ашигт малтмалын тухай" хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах замаар олборлолт, дамжуулан худалдаалалт, дахин боловсруулж өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бизнесийг дэмжих хууль эрх зүйн орчинг бий болгох.
4. Бизнесийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд хэт хутгалдаж байгаа төрийн захиргааны хяналтыг багасгах, аж ахуйн нэгжийн хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох зорилгоор "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг Засгийн газраас батлан гаргах зэрэг саналыг тавьж ажиллав.

Мөн Засгийн газрын 2010 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн "Орхон голын бохирдолтыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 264-р тогтоолыг гаргуулсан бөгөөд тогтоолын 4 дэх хэсэгт заагдсан Гол, мөрний бохирдолтыг хянах, бохирдолтын эх үүсвэрийг тогтоох зориулалт бүхий явуулын лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг тендер зарлан худалдан авч, хяналт шалгалтад хэрэглэж байна.

ЭБЭХЯ-аас ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд олгох нөхөн олговор тооцох ажлын тайлан, эхний ээлжинд цуцлагдах алтны ашиглалтын тусгай зөвшөөрлийн жагсаалтыг манай газарт 2011 оны 06 дүгээр сарын 08-ны өдөр а/1216 тоот албан бичгээр ирүүлсэн.

ЭБЭХЯ болон БОАЖЯ-аас өгсөн чиглэлийн дагуу уг хуулийн хязгаарлалтад хамаарсан 246 тусгай зөвшөөрөлтэй талбайд ашиглалт явуулах уулын ажлын төлөвлөгөөг батлалгүй түтгэлзүүлсэн болно.

”Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг хэрэгжүүлэх тухай Монгол улсын засгийн газрын 299 дугаар тогтоолыг 2011 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр манай газар хүлээн авч аймгуудын Мэргэжлийн хяналтын газруудад хүргүүлэн хяналт тавьж ажиллахыг даалган гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан. Уг тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 138 аж ахуйн нэгжийн 246 алтны шороон ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарагдаж байгаагаас 2011 оны эхний байдлаар үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоосон 26, уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулж байгаа 12, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулж байгаа 7, ашиглалтын үйл ажиллагаа явуулаагүй 185 тусгай зөвшөөрөл байв.

МХЕГ-ын 2011 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу газрын даргын баталсан 01/139 тоот удирдамжийн дагуу Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль түүнтэй холбогдон гарсан Засгийн газрын 2010 оны 264 болон 299 дүгээр тогтоолын 3 дахь заалтыг хэрэгжүүлэх үүднээс “Хил заагийг хэсэгчилэн тогтоох тухай” Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолд заасан хил заагт хамаарч буй алтны шороон ордуудын үйл ажиллагааг зогсоох, уурхайн хаалтын ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгүүлэх хяналт шалгалт 2011 оны 8 дугаар сарын 4-өөс 18-нд аймгуудын МХГ болон УМБГ-тай хамтран Архангай, Булган, Сэлэнгэ, Дархан, Төв, Хэнтий аймгуудад МХЕГ-аас хийгдсэн бол Баянхонгор, Өвөрхангай, Дорнод, Хөвсгөл, Увс аймгуудад нэгдсэн удирдамжаар аймгийн МХГ-ууд гүйцэтгэв.

Шалгалтаар МХЕГ-аас Архангай, Дархан, Сэлэнгэ, Төв, Булган, Хэнтий аймгийн 103 аж ахуйн нэгжүүдэд шалгалт хийж, зөрчил арилгуулах албан шаардлага 23-ыг өгч, улсын байцаагчийн акт 73-ыг үйлдэж, 55.216.000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч, хууль бусаар алт олборлосон 712,6 гр алтыг улсын орлого болгосон.

Үүнээс Архангай аймагт хийсэн шалгалтаар “Алтан Дорнод Монгол”, “Монгол газар” “Эм жи Эйч”, тусгай зөвшөөрлийн талбайд гэрээгээр ажил гүйцэтгэж буй 20 аж ахуйн нэгж болон “Алтай голд” ХХК-ийн үйл ажиллагааг актаар бүрмөсөн зогсоосон, мөн Ашигт малтмалын болон байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжинд заасан нутгийн захиргааны байгууллагын эрх үүргийг туйлын хангалтгүй хэрэгжүүлсэн, Засгийн газрын 2010 оны 264 дүгээр тогтоол, 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 30 дугаар тэмдэглэлийн 3 дахь заалтыг хэрэгжүүлэх талаар үр дүнд хүрсэн арга хэмжээ аваагүй, газар ашиглах зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг таслан зогсоох газрыг албадан чөлөөлүүлэх, тэдний үйл ажиллагаанаас байгаль орчинд үүссэн хохирлын хэмжээг тооцох ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар тооцуулж гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, голуудын голидролыг зураг төслийн дагуу нөхөн сэргээлгэх арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй талаар улсын байцаагчийн дүгнэлт гаргаж Архангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлж ажиллаа.

Дээрхи шалгалтаар аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг бүр мөсөн зогсоох улсын байцаагчийн шийдвэр гаргасан хэдий ч аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байгаа мэдээллийн мөрөөр БОАЖЯ, МХЕГ, УМБГ, МБОИЗ болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг 2011 оны 09 дүгээр сарын 10-15-нд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт ажиллаж тодорхой үр дүн гараагүй байна гэж үзэн, аймгийн Засаг даргад уг асуудлыг хугацаа алдалгүй нэн даруй шийдвэртэй арга хэмжээ авч дээрх хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, албадан гаргах арга хэмжээг гүйцэтгүүлэх асуудлыг тавьсан.

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт алт олборлох үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд шалгалтыг 2011 оны 4, 5 дугаар сард аймгийн МХГ-ын даргын баталсан 01/24 тоот удирдамж, 7 дугаар сард 01/34 тоот удирдамж, 8 дугаар сард МХЕГ-ын даргын баталсан 01/139 тоот, аймгийн МХГ-ын даргын баталсан 01/43 тоот удирдамжууд, 9 дүгээр сард 01/55 тоот удирдамжаар тус тус хийж гүйцэтгэсэн бөгөөд хууль, Засгийн газрын тогтоолуудыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан 20 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоосон ч лацыг хөдөлгөсөн аж ахуйн нэгжүүдэд 7390,0 мян.төгрөгний захиргааны арга хэмжээ ногдуулж, бохироор 32,2 гр алтыг хурааж, 10 машин механизмуудыг улсын орлого болгохоор түр саатуулсан.

Аймгийн МХГазрын дарга Ж.Эрдэнэ-Очирын зүгээс шат дараалсан дээрх хяналт шалгалтын мөрөөр хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг албадан хэрэгжүүлэх талаар дорвитой үр дүнд хүрсэн арга хэмжээ зохион байгуулж ажиллагаагүйгээс хууль бус үйл ажиллагаа даамжрах, байгаль орчин бохирдох үндсэн шалтгаан болсон тул МХЕГ-ын даргын 2011 оны ... тушаалаар ажлаас чөлөөлсөн.

Аймаг сумын зүгээс Ашигт малтмалын болон Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжууд мөн “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хууль түүнтэй холбогдон гарсан Засгийн газрын тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлдэггүйгээс гадна аж ахуйн нэгж тус бүрээс 5-10,0 сая төгрөгийг сум орон нутгийг хөгжүүлэх санд хандив болгон авсан нь хууль бус үйл ажиллагааг дэмжсэн үйлдэл болжээ.

МХЕГ-ын даргын баталсан нэгдсэн удирдамжаар аймгийн МХГ-аас Баянхонгор, Өвөрхангай, Дорнод, Хөвсгөл, Увс аймгуудад нийт 54 тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүд хамрагдсанаас 37 нь үйл ажиллагаа явуулаагүй, 17 нь олборлолт явуулж байсны 6 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг улсын байцаагчийн актаар зогсоож, 5 албан шаардлага өгч, 2.561.600 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллаа.

Илэрсэн зөрчилд ногдуулсан улсын байцаагчийн акт, шаардлагыг биелүүлээгүй, хууль бус үйл ажиллагаагаа үргэлжлүүлж буй аж ахуйн нэгжүүдийн үйлдэлийг таслан зогсоох, Эрүүгийн хуулийн дагуу арга хэмжээ авах талаар 2011 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 02/2567 албан тоотыг Цагдаагийн Ерөнхий газарт хүргүүлэн хамтран ажиллаж байна.

МХЕГ-ын дарга болон ЦЕГ-ын даргын хамтран баталсан “Хуулийн хэрэгжилт” тусгай арга хэмжээний удирдамжийг аймгийн МХГ-уудад хүргүүлж шалгалтыг 2011 оны 09 дүгээр сарын 14-өөс 21-нд гүйцэтгүүлэв. Энэхүү шалгалтаар усны эх бүрэлдэх болон ойн сан бүхий хилийн зааг дотор үйл ажиллагаа явуулж байсан 86 байгууллага, аж ахуйн нэгжийг илрүүлж, 19.7 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулж, 3 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналыг Ашигт малтмалын газарт хүргүүлж, 51 улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн, 83 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоож техник тоног төхөөрөмжийг битүүмжилсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэв.



Ийнхүү “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд МХЕГ-аас 2010 онд 1, 2011 онд 2 удаагийн нэгдсэн шалгалтыг улсын хэмжээнд зохион байгуулсан, харин аймаг, орон нутгаас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг удаа дараа зохион байгуулсны дүнд хуулиар хориглосон талбайд алт олборлох үйл ажиллагааг улсын хэмжээнд бүрэн зогсоож ажиллаа.

Монгол Улсын ерөнхий сайдын 2012 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 59 дүгээр захирамжинд заагдсан ажлын хүрээнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуульд хамрагдан нөхөн олговор авах хүсэлт гаргасан 124 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, байгаль орчныг хамгаалах багц хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн болон ашиглалтын талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй 10 аж ахуйн нэгж тус бүрт улсын байцаагчийн дүгнэлтүүдийг гарган 08/3930 тоот албан бичгээр Ашигт малтмалын газарт хүргүүлсэн.

Монгол Улсын ерөнхий сайдын 2013 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 34 дүгээр захирамжаар батлагдсан ажлын хэсгийн төлөвлөгөөнд заагдсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын тухай хуулийн 53.3-т заасан үүргээ хэрхэн биелүүлсэн болон, байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээ, түүнийг барагдуулсан эсэх, нөхөн сэргээлтийг хийсэн эсэх талаар дүгнэлтийг нэгтгэн гаргах” ажлыг зохион байгуулж байна.

Гэвч “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн үйлчлэлд хамаарч байгаа тусгай зөвшөөрлүүдийн талаарх мэдээлэл бүрэн гарсны дараа уг тусгай зөвшөөрлийн талбай бүрт “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулинд заасны дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэсэний үндсэн дээр дүгнэлт гаргах боломж бүрдэх тул мэдээлэлийг авах шаардлагатай байна.

## **МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**